



Б.Явуухулангийн яруу найраг дахь цаг хугацааны сэтгэлгээ, утга, бэлгэдэл ("Дөрвөн улирал" ерөнхий сэдэвт шүлгийн жишээн дээр)

Сандагдорж Нэргүйцэцэг*

Монгол улс, Цэцэрлэг, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Архангай аймаг дахь Багшийн сургууль, Хүмүүнлэгийн ухааны тэнхим

*Холбоо барих зохиогч: nerguitsetseg@msue.edu.mn

Хүлээн авсан: 2021.03.08

Хянагдсан: 2021.06.16

Зөвшөөрсөн: 2021.06.25

Хураангуй

“Дөрвөн улирал” сэдвийн хүрээнд монгол ардын аман зохиолын олон төрөл зүйл оньсого, таавар, цэцэн үг, ардын дуу, ерөөл, магтаал, бэлгэ үгээс эхлээд, сонгодог уран зохиолын уламжлалаар бичсэн шүлэг, яруу найраг, цаашлаад орчин үеийн уран зохиолчдын туурвисан шүлэг, найраглал гэхчлэн өргөн хүрээнд, арвин баялаг зохиол бүтээлүүд байдаг. Орчин үеийн уран зохиолын төлөөлөгчдийн нэг Б.Явуухулан уран бүтээлдээ дөрвөн улирлын өнгө аясыг зураглан илэрхийлэхдээ дүрсэлсэн уран дүрслэл, үгээр урлах, найруулах ур зүй, цаг хугацаа, улирлын талаарх мэдээлэл, лавлагаа, санаа, зохиомж, утга, бэлгэдэл, сэтгэлгээний цар хүрээ зэрэг хэрхэн илэрснийг түүний эл сэдэвт хамаарах шүлэг, найраглалыг түүвэрлэн, эхлээд “Хавар”, “Зун”, “Намар”, “Өвөл”-өөр нь сэдэвчлэн хувааж, дараа нь “Дөрвөн улирал” ерөнхий сэдвийн хүрээнд бичсэн шүлэг найраглалыг нь судалгааны хэрэглэгдэхүүн болгон, задлал хийв. Зохиолч Б.Явуухулан яруу найрагтаа цаг улирлын байдлыг, тухайлбал, дөрвөн улирлын зураглалыг дүрслэн илэрхийлснийг, тэрхүү дүрслэлд үндэстний сэтгэлгээний онцлог хэрхэн илэрснийг түүний “Дөрвөн улирал” ерөнхий сэдвийн дор туурвисан яруу найраг, яруу найргийн мөртүүд дэх баримтуудад түшиглэн, тодруулна.

Түлхүүр үг

хавар - ирж буй цаг, зун - дэлгэрч буй цаг, намар - харьж буй цаг, өвөл - хүйтрэх цаг, бэлгэдлийн утгат дүрслэлт үгс, цаг хугацааны утгат нийлэмж үгс

Удиртгал

“Сэтгэлгээ нь үндэстэн, угсаатны шинжтэй, аль эсвэл хувь хүний хандлага, оюуны цараатай холбоо бүхий утгатай нэрлэлт болдог” (Оюун, 2019, х.114), цаашлаад “Хэл сэтгэлгээ хоёр харилцан нягт холбоотой боловч сэтгэлгээ нь хэлний ялгаа үүсгэдэг үндсэн хүчин зүйл гэж үзэхийн зэрэгцээ аливаа хэл тодорхой дүрээр ертөнцийг төсөөлдөг гэх юм уу, эсвэл хүн хэлээр дамжуулж амьдралын тухай төсөөлөлтэй болдог гэсэн үзэл хандлага байдаг” (Эрдэнэсан, 2020, х.20) гэсэн

судлаачдын тодорхойлолтод “Сэтгэлгээ гэдэг нь хүний төрөлх чанараас гарч ирэх санаа” (Цэвэл, 1966, х.507) гэх тайлбар бүрнээ нийцэж байна.

Монгол үндэстэн байгалийн улирлыг төрөл бүрийн юм, үзэгдэлтэй адилтган дүрсэлдэг. Энэхүү адилтгал нь бэлгэдлээр дамжин илэрдэг, өөрөөр хэлбэл, үндэстний сэтгэлгээний онцлогийг илрүүлэх чухал хэрэглүүрийн нэг нь бэлгэдэл болдог байна. “Аливаа улс үндэстний яруу найргийн сэтгэлгээний өвөрмөц чанарыг илэрхийлэх шинж бий. Тэр нь тухайн орны байгалийн онцлогтой холбоотой. Эгц өндөр хадан байцас, омогт хүрэн бүргэд, их цасан нурлага, уулын голын шуугиант ширүүн урсгал зэрэг нь Кавказын яруу найргийн өнгө төрхийг илэрхийлдэг бол, дорнын цагаан сар, тэнгис далайн хярхаг дээгүүр хөвж яваа улаан нар, тэргүүлэгч цэцгийн цагаан түрүү, хулсан лимбэний исгэрэх аялгуу зэрэг нь Хятадын яруу найргийн шинж болоод гоолиг цагаан хус мод Оросын яруу найргийн бэлгэ тэмдэг байх жишээтэй. Тэгвэл монгол яруу найргийн онцлог дүр төрх нь эргэх дөрвөн цагтайд буй” (Мэнд - Ооёо, 2007, х.29-30), мөн үүнд холбогдох “Орос улсын бэлгэ тэмдэг нь хязгааргүй замууд, аль эсвэл гурвалсан морь, гурван хус мод”, эсвэл хязгааргүй тал, Кремлийн Спасс цамхаг, аль эсвэл Василий Блаженны сүм” (Арутюнова, 1999, х.340) гэсэн дүгнэлт ч байна.

Иймээс ч монгол хэлний уран сайхны эхэд, монгол яруу найрагт тодорхой зүйлийг бэлгэдэл утгаар дүрслэн үзүүлж, дөрвөн улирлын гол шинж, онцлог, зураглалыг бүтээн харуулдаг ажээ.

“Монгол нүүдэлчдийн сэтгэлгээ, түүний илэрхийлэл, уламжлал, шинэчлэл, үнэт зүйлс, утга соёлын хүрээнд нягтлан судалмаар олон сонирхолтой сэдэв байсаар байна. Түүний нэг бол нүүдэлчдийн аж амьдрал, хүн ба байгалийн харьцаа, утга соёлтой олон сэжмээр холбоотой “Эргэх дөрвөн цаг”, “Дөрвөн улирал”, “Дөрвөн далайн жам”, “Завдлагагүй дөрвөн далай”, “Дөрвөн цагийн аяс”, “Дөрвөн цагийн уянга”, “Дөрвөн улирлын зураглал” г.м. нэг ерөнхий сэдвийг олон хувилбараар илэрхийлсэн уран зохиолын бичил эхүүд (художественный текст или микромонолог) юм” гээд улмаар эл сэдэв нь бусад улс орны утга зохиолд төдий л олон байдаггүй бөгөөд монгол угсаа хэл шинжлэл, соёл хэл шинжлэл, нийгэм хэл шинжлэл, танихуйн хэл шинжлэл, уран сайхны эх задлал, уран сайхны дискурс, эхийн хэл шинжлэл, уран зохиол судлал, туурвил зүй, эхийн өгүүлбэрзүй зэрэг орчин цагийн соёл судлал, тогтвортой боловсрол, хэл судлал, уран зохиол судлалын асуудлуудтай уялдуулан судалж болох онол - хэрэглээний үлэмж ач холбогдолтой, бүр үндэсний гэмээр шинжтэй юм. Уг сэдвийн олон тал, юмны учир, сумны занги нь байгаль дэлхийн өгөгдөлдөө байдаг ч байж болох” (2010, х.249-250) гэсэн дүгнэлт, гаргалгааг эрдэмтэн Б.Пүрэв-Очир хийсэн нь дээр дурдсан зохиолч Г.Мэнд-Ооёогийн “... монгол яруу найргийн онцлог дүр төрх нь эргэх дөрвөн цагтайд буй” гэсэнтэй бүрнээ нийцэж байгаа билээ.

Эрдэмтэн Ч.Жачин “Д.Нацагдоржийн Дөрвөн цаг шүлэгт монголчууд хаврыг төлийн дуугаар (хонь), зуныг хүлэг морьдын уралдаанаар (адуу), намрыг үхэр мөөрөх дуунаар (үхэр), өвлийг тэмээн жингээр (тэмээ) мэдэрдгийг дүрсэлсэн нь бэлгэ тэмдэг юм. Иймээс ч Д.Нацагдорж энэ шүлгийнхээ гол санааг түүхэн ухамсар (историческое сознание), үндэсний мэдрэхүй (национальные чувства) (1987, х.34-36) гэж томьёолжээ” хэмээх тайлбарыг өгсөн байдаг.

Зохиолч Б.Явуухулангийн яруу найрагт дүрслэгдэж буй цаг хугацааны утгат нийлэмж үгс, тэдгээрийн бэлгэдэлт утгыг тодруулах, хувь зохиолчийн цаг хугацааны сэтгэлгээний цар хүрээг түүний бичсэн уран бүтээлд суурилан тодруулж, холбогдох үнэлэлт, дүгнэлт, тайлбарыг өгөх нь судалгааны ажлын гол

зорилго бөгөөд баримт задлан тодорхойлох арга, текст анализын аргыг тус тус хэрэглэв.

Их найрагчийн зохиол бүтээлд ажиглалт хийж, судлан шинжлэх явцад цаг хугацааны илэрхийлэлт, тэр дундаа “Дөрвөн улирал”-д холбогдох “Хавар ирлээ” (1953), “Хавар” (1955), “Нүүдэлчний намар” (1956), “Нуга дахь зуны өглөө” (1958), “Ой мод” (1963), “Хээр хоносон сар” (1963), “Намрын навчис” (1965), “Япон хайку маягаар бичсэн дөрвөн улирал” (1967), Миний араншин (1968), “Тэхийн зогсоол” (1969), “Эх орондоо” (1971) гэсэн 11 шүлэг, найраглал байгаагаас түүний цаг хугацааны талаарх ойлголт, мэдлэг, сэтгэлгээ ямар өргөн хүрээнд байсныг харж болохоор байна. Эдгээрээс, “Хавар - ирж буй цаг” хэсэгт “Хавар ирлээ”, “Хавар”, “Зун - дэлгэрч буй цаг” хэсэгт - “Нуга дахь зуны өглөө”, “Намар - харьж буй цаг” хэсэгт “Нүүдэлчний намар”, “Ой мод”, “Намрын навчис”, “Дөрвөн улирал” хэсэгт “Япон хайку маягаар бичсэн дөрвөн улирал”, “Миний араншин” шүлгийг тус тус хамааруулан авч үзсэнээс гадна “Алагхан дэлхий дуулж яваарай” (1961), “Гал” (1960), “Отгонтэнгэр”, “Эжий минь би маргааш явлаа” (1954), “Хүүхний дуу” (1959), “Пушкиний хөшөөний дэргэд” (1959), “Зөвлөлтийн мэргэжилтэн” (1978) зэрэг шүлэг, найраглалд мөн дөрвөн улирлын тухайт дүрслэл тусгагдсан тул тус тус задлан шинжилж, эдгээрээс эшлэн, холбогдох тайлбар, дүгнэлтийг хийв.

“Мал маллан амьдарч ирсэн нүүдэлчин монголчууд жилийн дөрвөн улирлыг халуун дулааны туйл болох зун, хүйтэн сэрүүний туйл болох өвөл хоёроор зааглан ойлгодог ба зун болохын урьтал болох хавар цагийг ирж буй цаг, өвөл болохын түрүүч болох намар цагийг харьж буй цаг хэмээн сэтгэдэг” (Батсуурь, 2012, х.44) гэсэнээс үүдэн хавар цагийг ирж буй цаг хэмээн сэтгэдэг нүүдэлчдийн сэтгэлгээ ёсоор бид судалгааны ажлын хүрээнд “хавар ~ зун ~ намар ~ өвөл” гэх уялдаа холбоонд задлан шинжлэл хийн, эхлээд улирал, улирлаар (хавар, зун, намар, өвөл) нь багцлан, тэрхүү улирал тус бүрд холбогдуулж түүсэн баримтад, дараа нь “Дөрвөн улирал” сэдэвт хамаарах шүлгийг бүхэлд нь баримт болгон тус тус задлал хийснийг дор авч үзнэ.

“Хавар – ирж буй цаг”

Нэг агшнаас нөгөө агшин, нэг хормоос нөгөө хором, нэг улирлаас нөгөө улирал, нэг цаг хугацаанаас нөгөө цаг хугацаанд шилжих нь цаг хугацааны мөнхөд үргэлжлэх үзэгдэл бөгөөд энэхүү шилжилт, тухайн цаг үе дэх мэдрэмж бүр өөр өөрөөр илэрхийлэгдсэн байдаг. Их найрагч Б.Явуухулан “Хавар ирлээ” шүлгийг 1953 онд бичсэн бөгөөд өмнө өгүүлсэн улирлын тэрхүү шилжилтийг,

“Зуун өнгийн жигүүртний дууг гангануулсаар

Зулзага нахиаг монос мойлоос нүдлүүлсээр

Зун намайг явууллаа, өөрөө айсуу гэсээр

Зугаат сайхан хавар эх оронд минь ирлээ.” хэмээн урнаар дүрслэн, шүлэглэсэн байдаг.

Тэрээр 1955 онд “Хавар” шүлгээ бичсэн бөгөөд энэхүү шүлэгт “өвөл” цагийн хахир хатууг соёлох, нахиалах, гөлөглөх, ургах, төлжихийн угтал “хавар” цаг халж, бууриа сэлгэж, сэтгэлээ шинэтгэж, шинэхэн улирлын өнгө төрхөд нийцэх, зохицох бэлтгэл юугаан хийсэн тухай өгүүлжээ. Энд өвөл цагийг,

“Цасан цагаан дахаа нөмрөөд

Мөсөн цэнхэр шилээ зүүгээд

Хавьтсан бүхнээ жавраар шилбүүрдэж

Хүйтэн царайлж цэхэлзсэн өвөл (-ийг)” “цасан цагаан дах” (-аа) нөмөр - (-өөд), “мөсөн цэнхэр шил” (-ээ) зүү (-ээд), хавьтсан бүхнээ жавар (-аар) шилбүүрд (-ж),

хүйтэн царайл (-ж) цэхэлз (-сэн) - өвөл хэмээн хүншүүлэн дүрсэлсэн ба “цагаан дах”, “мөсөн шил”, “хүйтэн царай” гэх эдгээр ухагдахуунууд өвөл цагийг бэлгэдэн үзүүлж, “шилбүүрдэх”, “хүйтэн царайлах”, “цэхэлзэх” гэдгээр сөрөг сэтгэлийн үнэлэмжийг илэрхийлжээ. Тэгвэл,

“Салхин зээрд морио унасан

Урьхан хавар мөрдөж ирээд

Мөсөн шилийг нь хайлгаад хөөлөө.

Цасан дахыг нь тайлаад явууллаа.” гэж нэгийг халж, нөгөөг солих нь цаг хугацааны жам ёс гэсэн дээрх санааг баталсан дүрслэл болсон байна. Цаашлаад,

“Ногоон торгон дээлээ өмсөж

Цагаан пансан алчуураа зангидаж

Хөх дурдан мөрнөө бүсэлж

Алаг цэцгээ хавар тэврээд

Усны шувуудын хоороо зогсоож

Урсгал ус, ой модон хөгжмөө суулгаж

Өвлийн өмнө өвдөг сөхрөөгүй тухай

Өөрөө удирдан магтан дуулж явна.” (Хавар, 1955) энэ нь олон янз өнгийн хосолмол, олон янз хувирахуйн илэрхийлэл хавар цаг хаяанд, хажууд, дэргэд дөтлөн, айлсан, өөрийн шинж тэмдгүүдээс нэг нэгээр, зугуу зугуугаар, аажим алгуураар мэдрүүлсээр, дасгасаар, зарлан тунхагласан тухайт дүрслэл бөгөөд “ногоон торгон дээлээ өмс –“ - *урган төлжихуйн*, “цагаан пансан алчуураа зангид - ” – *алаг цоог тарлантахуйн эсвэл олон янз салхлахуйн*, “хөх дурдан мөрнөө бүсэл - ” – *гол горхи хайлж урсахуйн*, “алаг цэцгээ тэвэр - ” - *урган төлжихж дэлгэрэхуйн*, “усны шувуудын хоороо зогсоо-“ *хавар цагийн зарлан тунхаглал шувуудын чуулахуйн* бэлгэдлийг тус тус илэрхийлсэн эерэг сэтгэлийн үнэлэмж илэрчээ. Бид энд дүрслэгдэж буй “ногоон торгон алчуур”, “цагаан пансан алчуур”, “хөх дурдан мөрөн” гэсэн өнгө заасан дүрслэлт нийлэмж үгсийг зохиогчийн “ногоон”, “цагаан”, “хөх” өнгийн мэдрэмж, дүрслэл, бэлгэдлийн талаар судлан шинжлэхдээ холбогдох хэсэгт тайлбарласан билээ.

“Зун – дэлгэрч буй цаг”

Их найрагч 1958 онд бичсэн “Нуга дахь зуны өглөө” шүлэгтээ цаг хугацааны орчил дахь үзэгдэл, юмс, хамаарлыг “үүлэн хархүү”, “нуга-бүсгүй” хэмээн хүншүүлэн илэрхийлж, байгалийн улирлын байдлыг, бие биеэс хамаарахуйн тухайт ойлголт, танихуйг,

“Үүлэн хархүү салхин хүлгээ унаж

Үдшийн тэнгэрт морин туурай пижигнэнэ.

Алагхан нуга цэцгэн алчуур даллавч

Алчуур дүүрэн шүүдрэн нулимстай үлдэнэ.

Шөрмөслөг хүлгээ гал бутартал ташуурдаж

Шөнийн цагаар үүлэн хархүү арилна.

Ногоон зуны өглөөний наранд дэлгэж

Нойтон алчуураа нуга - бүсгүй хатаана.” хэмээн уран яруугаар дүрсэлсэн байна. Шүлгийн мөртөд үүлэн хархүү, салхин хүлэг, үдшийн тэнгэр, морин туурай, алагхан нуга, цэцгэн алчуур, шүүдрэн нулимс, шөрмөслөг хүлэг, шөнийн цаг, ногоон зун, өглөөний нар, нойтон алчуур, нуга - бүсгүй гэх мэт нэрлэгдэхүүн буюу суурь мэдээллээр дамжуулан унах, пижигнэх, даллах, үлдэх, гал бутартал ташуурдах, арилах, дэлгэх, хатаах гэсэн нэрлэхүүн буюу зуны улирлын онцлог бүхий онцолбор мэдээллийг илрүүлэхдээ өгүүлэгчийн хөхин баясах эерэг сэтгэлийн үнэлэмжийг илэрхийлжээ.

“Алагхан дэлхий дуулж яваарай” гэсэн 1961 онд бичсэн шүлэгтээ,

“Саран гэрэлтсэн зуны үдшийг

Сайхан чи минь санаж байна уу?
Хонгор сэтгэлийн хайраа ханзалсан
Хорвоогийн үдшийг би мартахгүй.” хэмээн байгаль улирлын байдлыг хүний сэтгэлтэй холбон үзүүлсэн байдаг. Мөн “Гал”, “Отгонтэнгэр” шүлгүүдэд,

“Цэлмэг сайхан зуны өглөө
Цээжин биед нь нар тусна.” (Гал, 1960),
“Гангийн халуун зун

Мөнгөн мөндрөөр ундаалж ...“ (Отгонтэнгэр) “цэлмэг, сайхан - зун”, “гангийн халуун зун” гэсэн нийлэмж үгсээр зун цагийн шинж байдал, онцлогийг дүрсэлжээ.

“Намар – харьж буй цаг”

“Эжий минь би маргааш явлаа”, “Нүүдэлчний намар”, Хүүхний дуу”, “Пушкиний хөшөөний дэргэд”, “Ой мод”, Намрын навчис” шүлгүүдэд “намар” цаг, түүний бэлгэдэлт утгыг уран яруугаар дүрсэлснийг баримт болгон авав.

Довтлон ирэх он жилүүд, дөтлөн буй цаг хугацаа - өнгөрөх, үдлэх, дөтлөх гурван цагийн орчилд санан дурсах, санаж сэрэх, мөрөөдөн санахын үйлд эрхшээгдэн мөнхөд үргэлжилсээр байдаг, мөн л нөгөө ээлжлэн солигдох цаг хугацаа, эх үрийн удахгүй уулзан учрахын бэлгэдэлт утга бүхий,

“Намар буцсан	Нэг л мэдэхэд
Алаг ангир	Хүү чинь ирнэ ...” (Эжий минь би маргааш явлаа, 1954)
Хавар эргээд	хэмээн шүлгийн мөрнөө буулгажээ.
Ганганан ирдэг шиг	

Зохиогчийн 1956 онд бичсэн “Нүүдэлчний намар” шүлгийг “... нэгэн улирлын нэг сайхан монгол хавтгай зураг шиг болсон” (Пүрэв-Очир, 2011, х.264) гэж үнэлэн хэлсэн байдаг.

“Нарс найгаа л	Тал шарлаа л
Навчис хийсээ л	Мал холхио л
Уулын оройд будан суугаа л	Малчны сэтгэл гэнэт догдлоо л
Шувуу буцаа л	Салхи сэвээ л
Хяруу унаа л	Өрх дэвээ л
Өвсөн толгойд цан буугаа л	Өлөн тоос тэнгэрт босоо л

Айлууд нүүгээ л
Амрагууд холдоо л

Аяа хөөрхий нүүдэлчний намар аа гэж!”

энд нарс, навчис, будан, шувуу, хяруу, өвсөн толгой, тал, өрх - найгах, хийсэх, суух, буцах, унах, буух, шарлах, дэвэх гэж юмсын, мал - холхих гэж амьтны, малчны сэтгэл, айлууд, амрагууд - догдлох, нүүх, холдох гэж хүмүүний, салхи, тоос - сэвэх, босох гэж үзэгдлийн байдал, хөдөлгөөнийг тус тус нүдэнд харагдтал дүрслэн буулгасан нь зохиогчийн найруулахуйн эрэл хайгуулын нэг тал, монгол яруу найрагт оруулсан ур зүйн нэгэн онцлог юм. Зохиогч тодорхой зүйлсийг бэлгэдэл утгаар дүрслэн үзүүлэх аргаар намрын зураглалыг бүтээхдээ дээр жагсаасан юм, амьтан, хүн, үзэгдлийг заан нэрлэх ухагдахуун бүхий үгсээр илрүүлжээ.

“Монгол хүмүүс харилцаж нэвтрэлцэхдээ “аяа”, “хөөрхий” хэмээх баймж (аялга) үгсийг гадаад, дотоод яриандаа санамсартай, санамсаргүй байдлаар олон янз үүрэг, зорилготойгоор, үлэмж сонин байрлал, давтамжтайгаар хэрэглэсээр ирсэн уламжлалтай ажээ” (Пүрэв-Очир, 2009, х.72) гэсэн энэхүү тайлбартай холбоотойгоор энэхүү шүлгийн “Аяа хөөрхий нүүдэлчний намар аа гэж!” хэмээх дүгнэлтийн шинжтэй энэхүү өгүүлбэр дэх “Аяа хөөрхий” нь өгүүлэгчийн гуниглан санагалзсан өнгө аяс утгыг илэрхийлжээ.

“Намар” сэдэвт холбогдох дараагийн шүлэг нь 1965 онд бичсэн “Намрын навчис” шүлэг нь юм.

”Найран дээрээс гараад иртэл Намрын навчис унаж байлаа Налгар тэнгэрээр шувуудтай цуг Нарлаг намар зэллэн одлоо.	Салхи ч үгүй нам гүм байтал Шарласан навчис хийсэж байлаа. Санаанд ч үгүй аж төрж явтал Санчигны минь үс цайж байлаа.	Налгар тэнгэрээр шувуудыг дагаж Зэллэсэн бүхэн эргэж ирнэ. Намрын навч шиг надаас хийссэн Залуу нас минь л эргэж ирэхгүй.”
--	---	--

Энд зүгээр нэг цаг улирлын тухайд бус ээлжлэн солигдох улирлын жам ёс, тасралтгүй үргэлжлэн эргэх тэрхүү цаг хугацааг хүний амьдралын мөчлөгтэй харьцуулж, цаг хугацаа гэдэг бол мөнхийн, хүний амьдралын нэг хэсэг буюу мөчлөг, тухайлбал, “залуу нас” хэзээ ч эргэж ирэхгүй гэсэн санааг илэрхийлсэн ба өгүүлэгчийн ухамсар мэдрэхүйн гуниглан, санаашрахауйн өнгө аясыг илтгэжээ.

“Намар” цагийн бэлгэдэлт утгын нэг, “намар”-ыг илэрхийлэх үгсийн нэг нь “навч” аж. Тиймдээ ч их найрагчийн уран бүтээлийн өвд “навч”-тай холбоотой, намрын дуулал бүхий шүлэг, шүлгийн мөртүүд цөөнгүй тохиолдож байна.

Тэдгээрт 1959 онд бичсэн “Хүүхний дуу” шүлэг дэх, “Навчис хийссэн намрын орой би Найз чамайгаа алсад үдсэн юм ... Галуу ганганах хаврын цагаар Залуу амраг минь хүрээд ирээрэй ...”,	1959 онд бичсэн “Пушкиний хөшөөний дэргэд” шүлгийн “... Навчис шарласан тэр нэг намрын Намтар түүхийг чинь сонгоо байлгүй!... ... Навчис хийссэн тэр нэг намар Нээрэн та уйтгарлаж билээ ...” мөртүүдийг нэрлэж болно.
---	--

1963 онд бичсэн “Ой мод” хэмээх энэхүү шүлэгт,
“... Гэвч
Унасан тэр модны
Үр үндэс тасрахгүй ээ.
Намар шилгээж
Газар унагасан үрий нь
гэж ертөнцийн юмс, үзэгдлийн харилцан хамаарал, жам ёсны тухай өгүүлж, үр шимт, үр өгөөжит байдлын тухайт эерэг үнэлэмж, зохиогчийн танин мэдэхүйн цараа тус тус илэрчээ.

“Өвөл – хүйтрэх цаг”

Монгол оньсого дахь,

“Шилийн гурван даваа Чилийм гурван хөндий Навчит гурван тал” Найртай гурван булаг”,	“Гунхсан гурван хүүхэн Гунихарсан гурван хархүү Хэцүү гурван чавганц Хэдэр гурван өвгөн”,	“Барцдын гурван даваа Навчин гурван цэцэг Баян гурван хангай Хүйтэн гурван хөндий”,	“Аав нь амгалан тайван Ээж нь цэнгэл сайхан Хүүхэн нь гунхал сайхан Хүү нь ширүүн хар” (Өлзийхутаг, 2013, х.32-33)
--	--	--	--

гэх хүншүүлэлт дүрслэлүүдээр дамжуулан, даваа, хөндий, тал, булаг, хүүхэн, хархүү, чавганц, өвгөн, цэцэг, хангай-аар улирлыг төлөөлүүлэн, эдгээрийн шинжийг шилийн, чилийм, навчит, найртай, гунхсан, гунихарсан, хэцүү, хэдэр, барцдын, навчин, баян, хүйтэн хэмээн тодотгосон нь бидний дээр өгүүлсэн дөрвөн улирлын дүр төрх, шинж байдлыг бэлгэдлийн аргаар дүрслэн үзүүлдэг гэдэгтэй нийцэж байгаа болно. Энэ нь аман зохиолын төрөл зүйлийн нэг болох

дөрвөн улирлын сэдэвт холбогдох оньсогод ч бэлгэдэн үзүүлэх энэ арга илэрч буйг нотолж буй хэрэг юм.

Судалгаанд хамруулан түүвэрлэсэн,

(1) “Цан хүүргээ шавшин үлээсэн Царцам өвөл ирэхэд ч тэр, Хахир хатуу догшин амьсгалт Хаврын агаар ирсэн ч тэр,” (Хадлан, 1949),	(3) “Өвлийн цан модонд хүүрэглэж Өмнө чинь зогсоход хүйтэн тачигнавч Галтай халуун шүлгийн чинь мөрүүд Галын илч шиг дулаацуулж байна.” (Пушкиний хөшөөний дэргэд, 1959),
(2) “Өвлийн цагт Цас хэчнээн хунгарлавал Хөмгийн ногоо Төчнөөн их сугсарна.” (Сул шүлэг, 1959),	(4) “Хүн амьтангүй хөдөө хээрийн Эзгүй талд, Хүүрэг манарсан цаст өвлийн Шөнө дунд ...” (Зөвлөлтийн мэргэжилтэн, 1978)

баримт дахь “цан хүүргээ шавшин үлээх” - “царцам өвөл”, “цас хунгарлах”, “өвлийн цан модонд хүүрэглэх”, “хүүрэг манарах” гэх мэт нь өвлийн улирлын зураглалыг илэрхийлэх бэлгэдэлт үгс болно. Чухамдаа өвөл цагийн хүйтэн, хатуу, хахир байдлыг илэрхийлэх хатуу өвөл, хүйтэн өвөл, чөмөг царцам өвөл, жавар тачигнасан өвөл зэрэг үгс; өвлийн бэлгэдэлт “цас” хэмээх үгийн орох, унах, хялмаалах, будрах, бурганах, лавсах, малгайлах, хайлах, ханзрах, цармах, шуурах, хярмаглах, баргах, болих, бөмбийтөл дарах, хайлж газар цоохортох, халтартах, хөлрөх, хөрлөх, цартах, ихдэх, цаслах, алаг цоог болж цоохортох, ов тов цоохор болох, шижигнэх зэрэг цас, түүний үйлийг илэрхийлэх эдгээр үгсийн утгыг монгол хүн л таньж, ялгаж, эдгээр үгсээр дамжуулан сэрж, мэдэрч, ухаарч, эргэцүүлдэг билээ. Үүний цаана монгол сэтгэлгээний цар хүрээ оршдог аж. Дээрх жишээ баримт дахь “хүүрэг манарсан цаст өвөл”, “цан хүүргээ шавшин үлээсэн царцам өвөл” зэрэг үгс нь хувь зохиолчийн үгийн сан дахь эрдэнэсийн нэг, өвлийн шинжийг бүрнээ тодотгон харуулахуйц үгс юм.

Баримт (1), (2) -т, өвлийн улирал хүрэлцэн ирсэн ч хураасан хадлангийн хүчээр даван гарч чадна, цас ихээр хунгарлах нь газар дэлхийг дэвтээн, тэжээн, чийглэн, ундаалан байх үр шимт байдлын болоод чийгэнд ханасан газар дэлхий уур юугаан савсаан, ногоо юугаа суга өсгөн талархлаа илэрхийлэхээр завдан буйн тухайт эерэг үнэлэмж, баримт (3) -т, хүйтэн хахирыг ч ялан дийлэх гал халуун шүлгийн мөрүүд байдаг хэмээн, “хүйтэн-халуун”-ыг харшуулан өөдрөг тэмүүлэлт байдлын илэрхийлэлт эерэг үнэлэмж, баримт (4) –т, “эзгүй тал”, “шөнө дунд” хэмээх орон зайн орчил дахь сөрөг үнэлэмж тус тус илэрчээ.

“Дөрвөн улирал” сэдэвт хамаарах “Япон хайку маягаар бичсэн дөрвөн улирал”, “Миний араншин” гэсэн хоёр шүлэг байна. 1967 онд бичсэн “Япон хайку маягаар бичсэн дөрвөн улирал” шүлэг нь 1-4 хүртэл тус тусад нь дугаарласан бүтэцтэй,

“Хавар” (I) “Хашаа бууцны хөлөөр Хар турлиах сүрэглэн ирж Хөлдүүс ховхлон гүйлдэнэ.”	“Намар” (III) “Бургаст голын тохойн Буруу эргэсэн цөөрөм дээр Өнчин шар навч эргэлдэнэ.”
“Зун” (II) “Амаа өдөржин ангайж Атан тэмээ нүцгэн биедээ Хүйт мөрөөдөн зогсоно.”	“Өвөл” (IV) “Өвөр нөмөрт бараантах Өвөлжөө бууцны хөл өөд Малын жим яарна.”

Энэхүү шүлэгт хаврыг шувуу (хар турлиах), зуныг халуун (атан тэмээ ангайн хүйт мөрөөдөн зогсох), намрыг ургамал (өнчин шар навч), өвлийг үзэгдэл малын жим) - ээр мэдэрдгийг, өөрөөр хэлбэл хавар болохоор турлиах олноор сүрэглэн

ирж, “улаан хошууг” тэр шувуу олшроход хавар ирсний дохио хэмээн үзэх, усгүйгээр удаан хугацаанд байж чадах тэмээ хүйт мөрөөдөн зогсох нь зуны аагим халууныг илтгэн харуулах, өнчин шар навч гэх нь намрын сүүлчийг дохиолох бөгөөд энэ нь намар цагийн төгсгөлийг илтгэн харуулах утгатай болох, өвлийн цагт үхэр сүрэг яг л нэг жимээр цувран явах нь өвөл цагийн дүр зураг болох зэрэг нь бүгд монгол хүний ойлголт, танихуй, ахуйн дүр зураглалын нэг бөгөөд ингэж дүрсэлсэн нь бэлгэ тэмдгийг үгээр, монгол ухаанаар чадамгай илэрхийлсний нотолгоо юм.

1968 онд бичсэн “Миний араншин” нь өвөрмөц, содон дүрслэлтэй шүлгийн нэг бөгөөд зарим үед он цагийг хүлээж ядан, эсвэл барж ядан, бүр салж ядан байснаа, өнгөрөн одохын зуурт түүний удааныг эсвэл хэт хурдныг гайхан шагшрах хүмүүний эсрэгцэлт бодол, бие биетэйгээ ижилсэн нийцэж, эвцэн ижилсэж, эсрэгцэн зөрөлдөхийн утгат, дөрвөн улирлын мөн чанар хийгээд шинж чанар, дөрвөн улирлыг бэлгэдэх ёсон, улирлын өнгө аяс, онцлог, хүмүүн ба байгалийн харьцаа, уянга бүрнээ цогцолсон шүлгийн нэг юм.

<p>Зуны цагт өвлийг хүсэмжлэх (1) - “Хөхөөн дууны ногоохон зунаар Хөвч хангайнхаа зусланд байхдаа Хавтгайн чөмөг царцам өвлөө Харах сан гэж хүсдэг шигээ би, Цэцэгт хангайдаа давхиж явахдаа Цэнхэрхэн говьдоо очих сон гэж яарах юм.”, Өвлийн цагт зуныг мөрөөдөх (2) - Буурын шүдний хангинах өвлөөр Бударганат говийнхоо өвөлжөөнд байхдаа Хандгай аяндаа хөлрөм зунаа Харах сан гэж хүсдэг шигээ би, Алтан говьдоо давхиж явахдаа Аглагхан хангайдаа очих сон гэж яарах юм.</p>	<p>Хаврын цагт намрыг хүсэмжлэх (3) - “Цэнхэр яргуй нүдлэх хавраар Цэлгэрхэн талынхаа хаваржаанд байхдаа Өнчин янзага өөхлөх намраа Үзэх сэн гэж хүсдэг шигээ би, Цайдам талдаа давхиж явахдаа Цастайхан ууландаа очих сон гэж яарах юм.”, Намрын цагт хаврыг мөрөөсөх (4) - “Халиун буганы урамдаа намраар Хан уулынхаа намаржаанд байхдаа Ууган төл цангинах хавраа Үзэх сэн гэж хүсдэг шигээ би, Үүл шүргэсэн ууланд явахдаа Өргөнхөн талдаа очих сон гэж яарах юм. “</p>
--	---

гэсэн эсрэгцэлт өгүүлэмжийн дунд бүтэцжүүлэн, дөрвөн улирал болоод дөрвөн зохицол, тогтцын байдал шинжийг ухамсар мэдрэхүйн хөхин хөгжих, хүсэн мөрөөдөх эерэг үнэлэмжээр илэрхийлсэн ба,

“Энэ бүхэн миний араншин,
 Эцэг эхээс өвлөсөн араншин
 Өвөл, зун, хавар, намаргүй


Уул, тал, хангай, говьгүй
 Тийм нутагт сэтгэл минь тогтохгүй,
 Тэгээд ч би амьдарч чадахгүй!”

гэж хүний араншин гэдэг тогтворгүй, ямагт хувьсан өөрчлөгдөж байдаг, дөрвөн улирал, газар орны дөрвөн өөр зохицол, тогтоц бүгд заяасан Монгол орондоо эзэн нь байна гэсэн омогшин бахархах, бахдах, нотлон батлах өнгө аяс болоод сэтгэлийн илэрхийлэл дүрслэгджээ.

Энэхүү шүлэгт дөрвөн улирал, дөрвөн зохицол, тогтцыг нэг шугамд зэрэгцүүлэн, байршуулж, тэдгээрт хамаат дүрслэлт нийлэмж үгсийг сонгон хэрэглэсэн нь дан ганц хувь зохиолчийн, тухайлбал Б.Явуухулангийн өөрийн урлал зүйд, бүтээн туурвихуйд ашигласан, хэрэглээ болгосон шинэ санаа, дүрслэлийн уран санаа, зохиохуйн бүтээлч хандлага юм.

Шүлгийн бүтцийг авч үзвэл, дараах байдалтай байгаа бөгөөд, эндээс дөрвөн улирлын зураглалыг илэрхийлэхүйц бэлгэдлийн утгат дүрслэлт үгсийг, монгол хүмүүний оршин амьдрахуйн орон зайн орчлыг харж болохоор байна.

Зун, намар, өвөл, хавар ~ хангай, говь, тал, уул



Дүгнэлт

“Дөрвөн улирал” ерөнхий сэдэвт холбогдох шүлгүүд дэх онцолбор мэдээлэл нь “хавар”, “зун”, “намар”, “өвөл”, “дөрвөн улирал” буюу цаг хугацаа байгаа бөгөөд эдгээрийг илрүүлэх үндсэн суурь мэдээлэл болох орон зай, цаг хугацаа, байгаль ертөнц, хүн байгалийн харьцааг илэрхийлсэн дүрслэлт нийлэмж үгсээр улирлын ээлжлэн солигдох үзэгдлийг дүрслэн үзүүлэхдээ тухайн шинж байдлыг энгийн тоочих, ирэх, үдлэх, буцах цаг хугацааг таашаах, эс таашаах гэхчлэн сэтгэлийн өнгө аяс, үнэлэмжийн хандлагыг жам ёсоор улиран солигдохоор төлөөлүүлж, адилтган, зүйрлэн, хүншүүлэн, амьдчилан илэрхийлжээ.

Зохиолч Б.Явуухулан яруу найрагтаа “Дөрвөн улирал”-ын зураглалыг бүтээхдээ байгалийн улирлыг төрөл бүрийн юм, үзэгдэлтэй адилтган дүрсэлж, энэхүү адилтгал нь тодорхой бэлгэдэлт утгуудыг илэрхийлсэн ба үндэстний сэтгэлгээний өвөрмөц онцлог тодорхой илрэн гарчээ.

Ном зүй

- Арутюнова, Н.Д. (1999). *Язык и мир человека*. 2 - е изд, “Языки русской культуры”: Москва: Наука
- Батсуурь, Г. (2012). *Дөрвөн цагаас Цаг хугацаа амсхийх ... хуртэл*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК
- Жачин, Ч. (1987). *Зохиолын эх бичигт хийсэн ажиглалт, тэмдэглэл*. Улаанбаатар: Битпресс ХХК
- Мэнд-Ооёо, Г. (2007). *Яруу найргийн шидэт долгион 1*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК
- Оюун, Ц. (2019). *Хэл, соёл, сэтгэлгээ*. Улаанбаатар: Хөх Монгол Принтинг ХХК.
- Өлзийхутаг, Ц. (2013). *Монгол ардын түмэн оньсого 1*. Улаанбаатар: Монсудар.
- Пүрэв-Очир, Б. (2009). *Үг, өгүүллэрийн амьдрал аранишин, эрчим энерги, соёл хэрэглээ*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК
- Пүрэв-Очир, Б. (2011). *Үг, өгүүллэрийн амь, амьдрал, эрчим долгион, соёл хэрэглээ*, Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК

Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр

Эрдэнэсан, Д. (2020), Уран сайхны эхэд өгүүлэгчийн ертөнцийг үзэх үзэл, үндэстний сэтгэлгээний онцлог илрэх нь, *МУБИС, МоСС, Монгол судлалын чуулган эрдэм шинжилгээний бичиг*. Улаанбаатар: Жиком

The Mind, Meaning, and Symbol of The Poetry of B.Yavuukhulan (In the Example of the General Topic “Four Seasons”)

S.Nerguitsetseg*

Department of Humanities, Teacher’s School, Mongolian National

University of Education, Tsetserleg, MONGOLIA

*Corresponding author: nerguitsetseg@msue.edu.mn 

Received: 3/08/2021/

Revised: 6/16/2021

Accepted: 6/25/2021

Abstract

In this article, we researched the expression of the four seasons, the poetic imagination, word art, style, information of time and seasons, inquiries, ideas, literary forms, meanings, symbols, and the extent of the mindset of poems and lyrics of B.Yavuukhulan, one of the representatives of the modern literature. We collected his poetry works that applied to this topic and divided them by topics “Spring”, “Summer”, “Autumn”, and “Winter”, and analyzed his poetry works within the general topic “Four seasons” using them as the research tool. We will clarify the depiction of the time and seasons and the expression of the specific sense of the national mentality in the poems of poet B.Yavuukhulan based on the evidence of his poetry lines under the topic “Four seasons”.

Keywords

Spring- Coming time, Autumn - Going time, Winter- Cold time, Summer- Blooming time, symbolic descriptive words, compound words and expressions of time.
